

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН САНХҮҮГИЙН ЖИЛ ЭХЛЭХ, ДУУСАХ
ХУГАЦААНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ**

Р.Нургүл, Р.Өнөрсайхан

АГУУЛГА

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН САНХҮҮГИЙН ЖИЛ ЭХЛЭХ, ДУУСАХ
ХУГАЦААНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Нэг. Санхүүгийн жилийн тухай ойлголт
Хоёр. Дэлхийн улс орнуудын санхүүгийн жилийн талаарх лавлагаа
(хүснэгтээр)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН САНХҮҮГИЙН ЖИЛ ЭХЛЭХ, ДУУСАХ ХУГАЦААНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

Нэг. Санхүүгийн жилийн талаарх ойлголт

Санхүүгийн жил гэдэг нь санхүүгийн тайлан тооцоогоо тооцон, тайлан гаргаж, татвар төлдөг хугацааг хэлнэ. Улс орнуудын санхүүгийн жил 12 сартай байх бөгөөд эхлэх, дуусах хугацаа нь харилцан адилгүй байдаг.

ОУВС-ийн гишүүн орнуудын 70 хувь нь Григорийн тоолол буюу хуанлийн жилийг хэрэглэж байна. Бусад орнуудын хувьд санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацаа ялгаатай байдаг бөгөөд дуусах хугацаа нь хуанлийн жилийн 1, 2, 3-р улиралд байна. Харин цөөхөн улс орон шашныхаа тооллыг хэрэглэдэг⁴⁴. Дэлхийн улс орнуудын санхүүгийн жил нь дараах хугацаанд болдог байна. Үүнд:⁴⁵

- **1-р сарын 1-нээс 12-р сарын 31.** Латин Америкийн бүх улсууд, Африк тивийн франц хэлтэй улсууд, Европын ихэнх улсууд, Зүүн өмнөд Азийн ихэнх улсууд.
- **4-р сарын 1-нээс дараа оны 3-р сарын 31.** Британи болон тус улстай түүхэн холбоо бүхий Бруней, Канад, Энэтхэг, Сингапур, Өмнөд Африк зэрэг улсууд.
- **7-р сарын 1-нээс дараа оны 6-р сарын 30.** Австрали, Египет, Кени, Шинэ Зеланд, Пакистан, Танзани болон дэлхийн бөмбөрцгийн өмнөд хагаст оршдог ихэнх улс орнууд.
- **10-р сарын 1-нээс дараа оны 9-р сарын 30.** Америк (зөвхөн холбооны хэмжээнд), Тайланд, Тринидад Тобаго, Лаос зэрэг улсууд.
- **Шашны тоололтой (3-р сарын 21-нээс дараа оны 3-р сарын 20).** Иран, Афганистан зэрэг улсууд байна.

Улс орнуудын Засгийн газрын санхүүгийн жил нь түүхэн, улс төрийн болон цаг агаарын хүчин зүйлсээс хамаарч өөрчлөгдсөөр ирсэн. Үүнд дараах хүчин зүйлүүд нөлөөлдөг гэж үздэг.⁴⁶

Засгийн газрын үйл ажиллагааны мөчлөг (*The government business cycle*).

Улс орнуудын Засгийн газар нь өөрийн гэсэн үйл ажиллагааны мөчлөгтэй байх бөгөөд тодорхой хугацаанд төсвийн орлогын ихэнх хэсгийг төвлөрүүлэх, эсхүл их хэмжээний төлбөрүүдийг төлдөг байна. Зарим тохиолдолд Засгийн газар санхүүгийн жилийн дуусах хугацааг сонгохдоо жилийн эцсийн орлого, зарлагын урсгал ихээхэн хэлбэлзэлтэй үеийг сонгохоос зайлсхийсэн нь дээр гэж үздэг. Учир нь Засгийн газрын орлого, зарлагын төсөөллийг илүү бодитой болгох, төрийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулахад хэцүү байх магадлалтай.

⁴⁴ОУВС-ийн Санхүүгийн хэрэг эрхлэх албаны Төрийн санхүүгийн удирдлагын 2-р хэлтсийн зөвлөх Guohua Huang, тухайн албаны орлогч дарга Holger van Eden нарын ОУВС-ийн блог хуудсанд нийтэлсэн нийтлэл. <https://blog-pfm.imf.org/pfmblog/2016/10/the-timing-of-the-governments-fiscal-year-.html>

⁴⁵мөн тэнд

⁴⁶мөн тэнд

Хэрэв тухайн орны хөрөнгийн зах зээлийн боломж хязгаарлагдмал бөгөөд Засгийн газар санхүүгийн жилийн эхэнд л орлого олдог бол энэхүү нөхцөл байдал нь хүндрэл үүсгэж болзошгүй. Ийм нөхцөлд улс орнууд санхүүгийн жилээ хуанлийн жилээс ялгаатай сонгодог. Тухайлбал, Британи улстай адил татварын жил болон санхүүгийн жил нь 2 өөр байхаар зохицуулж болно.

Цаг агаарын нөхцөл, нийтээр тэмдэглэх баяр, түүхэн үйл явдлууд (*Climate, public holidays, historic events*). Газар тариалан эрхэлдэг улс орнуудын хувьд төсвийн орлого, зарлага нь ургац хураах улирал, мөн түүнчлэн борооны улирал зэрэг цаг агаарын хүчин зүйлээс хамаарна. Түүнээс гадна урт үргэлжилдэг нийтээр тэмдэглэх баярын хугацаатай санхүүгийн жилийн дуусах хугацаа давхцах нь тохиромжгүй гэж үздэг. Учир нь хувь хүмүүс баярт зориулж ихээхэн зарлага гаргаснаас тэдний санхүүгийн бололцоо буурах ба энэхүү нөхцөл байдал нь эдийн засагт савалгаа үүсгэх магадлалтай тул санхүүгийн жилийн эцсийн тайлан гаргахад тохиромжгүй үе юм.

Компаниудын санхүүгийн жил (*Alignment with the fiscal year of companies*). Улс орнууд хөдөө аж ахуйн эдийн засгаас бүтээгдэхүүн үйлдвэрлэлд түшиглэн хөгжихийн хэрээр төрийн санхүүг төлөвлөн удирдахад хувийн компаниуд чухал үүрэг гүйцэтгэх болсон. Эдийн засгийн бүх салбар дахь төлөвлөлтийн үйл явц зэрэгцэж (ижил хугацаанд) байвал эдийн засгийн өсөлтийг таамаглах нь илүү хялбар болно. Компаниудын санхүүгийн жилийн хугацаа ижил байвал хувийн секторын үйл ажиллагааг санхүүгийн бодлогоор дэмжихэд илүү үр ашигтай байх бөгөөд өөр өөр санхүүгийн жилтэй бол энэхүү үр ашиг буурна. Ийнхүү ашигтай талыг бодолцож дэлхийн томоохон компаниудын дийлэнх нь санхүүгийн жилээ хуанлийн жилтэй адилхан сонгодог байна.

Татварын жил (*Tax year*). Энэ нь Засгийн газрын үйл ажиллагааны мөчлөгийн нэг хэсэг байхаас гадна компаниудын үйл ажиллагааны мөчлөгтэй ч холбоотой байдаг. Иймд татварын жилийг өөрчлөх талаарх Засгийн газрын шийдвэр нь компаниудад, ялангуяа үндэстэн дамнасан корпорациудад сөргөөр нөлөөлж болзошгүй. Тийм учраас татварын жилийг өөрчилснөөс санхүүгийн жилийг өөрчилсөн нь илүү дээр гэж үздэг байна. Гэхдээ Америк, Их Британи зэрэг улсуудад татварын алба нь аж ахуйн нэгжүүдэд татварын жилээ өөрсдөө сонгохыг зөвшөөрдөг. Энэ тохиолдолд татварын мөчлөг нь санхүүгийн жилийг тодорхойлоход ач холбогдол багатай байна.

Статистик тайлан тооцооны хугацаа (*Statistical accounting period*). Европын Холбоо, Африкийн эдийн засгийн болон бусад холбоо, нэгдлүүд санхүүгийн жил болон статистик тайлан тооцоо гаргах цаг хугацаа ижил байх нь илүү ач холбогдолтой гэж үздэг. Учир нь гишүүн улс орон бүрийн Засгийн газрын мэдээллийг нэгтгэхэд илүү хялбар байх болно. Мөн жилийн төсвийг бэлтгэх болон макро эдийн засаг, үндэсний санхүү бүртгэлийн статистик мэдээллийг боловсруулах цаг хугацаа нь ижил байвал эдийн засгийн хувьсагчдыг илүү сайн ойлгох ач холбогдолтой. Ихэнх улс орнууд үндэсний санхүү бүртгэл болон төлбөрийн тэнцлийг хуанлийн жилд, харин Австрали, Гайти (Хаити), Непал зэрэг улсууд санхүүгийн жилдээ гаргадаг.

Хууль тогтоох байгууллагын хуанли (*Calendar of the Legislature*). Засгийн газрын санхүүгийн жил нь хууль тогтоох байгууллагын хуанлитай ижил байх ёстой. Ингэснээр парламентад төсвийг хянах хангалттай хугацаа олгох юм. Парламент төсвийг баталж дууссаны дараа санхүүгийн жил эхлэх ёсгүй байдаг. Энэ дүрэм нь Хятад улсын төсвийн хэрэгжилтэд хүндрэл учруулдаг учир үүнд ихээхэн анхаарал хандуулдаг. Хятадын санхүүгийн жил нь 1-р сарын 1-нээс эхэлдэг боловч Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал улсын төсвөө 3-р сарын сүүлээр баталдаг бөгөөд жилийн эхний 3-4 сард хөрөнгө оруулалтын зардлууд, Засгийн газрын шилжүүлэг, шинэ бодлого хэрэгжүүлэх зардал, хөтөлбөрүүдийг түр зогсоодог.

Өнгөрсөн хугацаанд үйлдвэрлэл хөгжсөн болон хөгжиж буй цөөн хэдэн улс санхүүгийн жилээ өөрчилсөн байна. Үүнд⁴⁷:

- 1976 онд АНУ-ын Холбооны Засгийн газар нь санхүүгийн жилээ 7-р сарын 1-нээс 6-р сарын 30 байсныг 10-р сарын 1-нээс 9-р сарын 30 болгож өөрчилсөн. Энэ нь Конгресст холбооны төсвийг хянах, боловсронгуй болгоход илүү их цаг хугацааны боломж олгосон байна.
- 1989 онд Шинэ Зеланд 4-р сарын 1-нээс 3-р сарын 31 байсныг 7-р сарын 1-нээс 6-р сарын 30 болгон өөрчилсөн. Ийнхүү өөрчлөх болсон шалтгаан нь жилийн эцэст макро эдийн засаг болон төлбөрийн балансын өгөгдлүүдийг тайлагнахад илүү тохиромжтой үеийг сонгох, түүнчлэн санхүүгийн жилээ хөрш Австрали улстай уялдуулах зорилготой.
- 2009 онд Зүүн Тимор улс санхүүгийн жил нь 7-р сарын 1-нээс 6-р сарын 30 байсныг өөрчилж хуанлийн жилтэй ижил болгосон ба макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг нийтлэн гаргах хугацаатай уялдуулсан байна.
- 2016 онд Фижи улс төсвийн үйл явцыг Засгийн газрын үйл ажиллагааны мөчлөгтэй уялдуулах зорилгоор санхүүгийн жилээ өөрчлөх шийдвэр гаргасан бөгөөд хуанлийн жилтэй ижил байсныг 8-р сарын 1-нээс 7-р сарын 31 болгон өөрчилсөн байна.

Эдгээр улсуудын санхүүгийн жилийн өөрчлөлт нь ерөнхийдөө хэвийн явагдсан. Энэхүү өөрчлөлттэй холбогдуулан төсвийн үйл явц болон санхүүгийн системийг уялдуулах, санхүүгийн болон аудитын тайлан боловсруулдаг ажилтнуудад сургалт хийх, мөн худалдан авалтыг төлөвлөх, гэрээ хэлэлцээр байгуулах хугацааг уялдуулан зохицуулах болон холбогдох бусад зардлууд гарсан байна.

Хэрэв Засгийн газар үйл ажиллагааны мөчлөгөө илүү уян хатан болгох зорилгоор санхүүгийн жилийг өөрчлөх шийдвэр гаргасан бол үүнтэй холбоотой орлого цуглуулах, эсхүл төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ямар нэг зохицуулалт хийх шаардлагагүй байж болно. Харин өөр бусад асуудалтай холбоотой бол Засгийн газрын ихэнх үйл ажиллагааны хугацааг өөрчлөх хэрэгтэй болдог. Энэ тохиолдолд Засгийн газрын үйл ажиллагааны мөчлөгийг, түүнчлэн эдийн засгийн бүх хүрээг уг өөрчлөлттэй уялдуулан зохицуулах болон зардлын түвшинг үнэлэх ихээхэн хүндрэлтэй байдаг. Хэдий тийм боловч гарцаагүй шаардлагатай бол улс орнууд санхүүгийн жилээ өөрчилдөг байна⁴⁸.

⁴⁷ОУВС-ийн Санхүүгийн хэрэг эрхлэх албаны Төрийн санхүүгийн удирдлагын 2-р хэлтсийн зөвлөх Guohua Huang, тухайн албаны орлогч дарга Holger van Eden нарын ОУВС-ийн блог хуудсанд нийтэлсэн нийтлэл. <https://blog-pfm.imf.org/pfmblog/2016/10/the-timing-of-the-governments-fiscal-year-.html>

⁴⁸мөн тэнд

Хоёр. Дэлхийн улс орнуудын санхүүгийн жил эхлэх, дуусах хугацаа

Энэхүү лавлагаа, мэдээлэлд нийт 151 улсын санхүүгийн жил эхлэх, дуусах хугацааг тив тус бүрээр ялган хүснэгтээр харуулсан болно.

Эдгээр улс орнуудаас Шинэ Зеланд, Сингапур, Япон, Тайланд, Америк, Канад, Их Британи зэрэг улсуудын Засгийн газар болон иргэн, хувийн хэвшлийн санхүүгийн жил өөр өөр хугацаанд болдог, харин АНУ-ын хувьд холбооны улсын хэмжээнд, муж улсууд, бизнесийн байгууллагууд тус тусдаа 3 өөр санхүүгийн жил хэрэглэдэг онцлогтой байна.

Хүснэгтэд харуулсан бусад улс орнуудын хувьд Засгийн газар болон иргэн, хувийн хэвшил нь нэг санхүүгийн жилтэй. Тэдний ихэнх нь буюу **106** улсын санхүүгийн жил 1-р сарын 1-нээс 12-р сарын 31-нд (хуанлийн жилд); **16** улсынх 7-р сарын 1-нээс 6-р сарын 30-нд; **7** улсынх 10-р сарын 1-нээс 9-р сарын 30-нд; **9** улсынх 4-р сарын 1-нээс 3-р сарын 31-нд байдаг байна. Харин Самоа, Балба, Афганистан, Иран, Этиоп зэрэг улсуудын санхүүгийн жил дээрх орнуудаас өөр байна.

Дэлхийн улс орнуудын санхүүгийн жилийн талаарх лавлагаа

Д/д	Улс орны нэр	Санхүүгийн жил эхлэх, дуусах хугацаа
АВСТРАЛИ, ДАЛАЙН УЛС ОРНУУД		
1	Австралийн Холбооны улс https://blog-pfm.imf.org/pfmblog/2016/10/the-timing-of-the-governments-fiscal-year-.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
2	Бүгд Найрамдах Вануату Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
3	Бүгд Найрамдах Кирибати Улс	
4	Маршаллын арлуудын Бүгд Найрамдах Улс https://www.indexmundi.com/marshall_islands/fiscal_year.htm	10-р сарын 1-нээс 9-р сарын 30
5	Холбооны Микронез Улс https://www.indexmundi.com/federated_states_of_micronesia/fiscal_year.html	10-р сарын 1-нээс 9-р сарын 30
6	Бүгд Найрамдах Науру Улс https://www.indexmundi.com/nauru/fiscal_year.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
7	Бүгд Найрамдах Палау Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	10-р сарын 1-нээс 9-р сарын 30
8	Панау-Шинэ Гвиней Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
9	Самоагийн Тусгаар Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	6-р сарын 1-нээс 5-р сарын 31
10	Соломоны Арлуудын Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31

11	Шинэ Зеланд Улс https://blog-pfm.imf.org/pfmblog/2016/10/the-timing-of-the-governments-fiscal-year-.html	Засгийн газар 7-р сарын 1-нээс 6-р сарын 31 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 4-р сарын 1-нээс 3-р сарын 31
12	Бүгд Найрамдах Фижи Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
13	Тувалу Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 3
АЗИ ТИВИЙН УЛС ОРНУУД		
14	Бүгд Найрамдах Хятад Ард Улс http://www.fdi.gov.cn/1800000121_39_2663_0_7.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
15	Хонконг https://en.wikipedia.org/wiki/Fiscal_year	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
16	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
17	Бүгд Найрамдах Энэтхэг Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
18	Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улс https://en.wikipedia.org/wiki/Economy_of_Myanmar	10-р сарын 1-нээс 9-р сарын 30
19	Бүгд Найрамдах Индонез Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
20	Камбожийн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
21	Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 16-аас 6-р сарын 15
22	Исламын Бүгд Найрамдах Афганистан Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	12-р сарын 21-нээс 12-р сарын 20
23	Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
24	Бүгд Найрамдах Ирак Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
25	Исламын Бүгд Найрамдах Пакистан Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
26	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	10-р сарын 1-нээс 9-р сарын 30
27	Арабын Бүгд Найрамдах Сири Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
28	Бүгд Найрамдах Турк Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
29	Бүгд Найрамдах Сингапур Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	Засгийн газар 1-р сарын 1-нээс 12-р сарын 31 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 1-р сарын 1-нээс 12-р сарын 31
30	Бүгд Найрамдах Йемен Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31

31	Исламын Бүгд Найрамдах Иран Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	3-р сарын 21-нээс 3-р сарын 20
32	Малайз Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
33	Япон Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	Засгийн газар 4-р сарын 1-нээс 3-р сарын 31 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 1-р сарын 1-нээс 12-р сарын 31
34	Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
35	Бүгд Найрамдах Филиппин Улс https://www.indexmundi.com/philippines/fiscal_year.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
36	Тайландын Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	Засгийн газар 10-р сарын 1-нээс 9-р сарын 30 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 1-р сарын 1-нээс 12-р сарын 31
37	Кувейт Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
38	Палестин Улс https://en.wikipedia.org/wiki/Economy_of_the_State_of_Palestine	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
39	Йорданы Хашимитын Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
40	Бутаны Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
41	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
42	Бүгд Найрамдах Солонгос Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
43	Израйль Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
44	Арабын Нэгдсэн Эмират Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
45	Бүгд Найрамдах Армен Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
АМЕРИК ТИВИЙН УЛС ОРНУУД		
46	Америкийн Нэгдсэн Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	Засгийн газар 10-р сарын 1-нээс 9-р сарын 30 Мужууд 7-р сарын 1-нээс 6-р сарын 30 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 1-р сарын 1-нээс 12-р сарын 31

47	Бүгд Найрамдах Куба Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
48	Бүгд Найрамдах Чили Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
49	Бүгд Найрамдах Аргентин Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
50	Канад Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	Засгийн газар 4-р сарын 1-нээс 3-р сарын 31 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 1-р сарын 1-нээс 12-р сарын 31
51	Мексикийн Нэгдсэн Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
52	Бүгд Найрамдах Коста-Рика Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	10-р сарын 1-нээс 9-р сарын 30
53	Бүгд Найрамдах Никарагуа Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
54	Бүгд Найрамдах Гайана Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
55	Бүгд Найрамдах Гренада Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
56	Бүгд Найрамдах Эквадор Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
57	Доминиканы Бүгд Найрамдах Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
58	Сент-Винсент ба Гренадин Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
59	Доминикийн Хамтын Нөхөрлөлийн Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 31
60	Бүгд Найрамдах Хондурас Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
61	Бүгд Найрамдах Панам Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
62	Ямайка Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
63	Антигуа ба Барбуда Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
64	Бүгд Найрамдах Суринам Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
65	Бүгд Найрамдах Хаити Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	10-р сарын 1-нээс 9-р сарын 30
66	Сент Люсия Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
67	Сент Кристофер ба Невисийн Холбооны Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
68	Бахамын Хамтын Нөхөрлөлийн Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30

69	Белиз Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
70	Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
71	Бүгд Найрамдах Колумби Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
АФРИК ТИВИЙН УЛС ОРНУУД		
72	Бүгд Найрамдах Гвиней Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
73	Бүгд Найрамдах Мали Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
74	Бүгд Найрамдах Ардчилсан Алжир Ард Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
75	Арабын Бүгд Найрамдах Египет Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
76	Бүгд Найрамдах Гана Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
77	Бүгд Найрамдах Конго Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
78	Бүгд Найрамдах Нэгдсэн Танзани Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
79	Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 8-аас 7-р сарын 7
80	Исламын Бүгд Найрамдах Мавритани Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
81	Төв Африкийн Бүгд Найрамдах Улс https://www.cabri-sbo.org/en/countries/central-african-republic	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
82	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
83	Бүгд Найрамдах Судан Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
84	Мароккогийн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
85	Холбооны Бүгд Найрамдах Сомали Улс https://www.cabri-sbo.org/en/countries/somalia	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
86	Холбооны Бүгд Найрамдах Нигери Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
87	Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
88	Бүгд Найрамдах Мозамбик Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
89	Бүгд Найрамдах Гвиней-Бисау Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
90	Бүгд Найрамдах Ардчилсан Сан-Томе ба Принсипи Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
91	Бүгд Найрамдах Кабо-Верде Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
92	Бүгд Найрамдах Ангол Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31

93	Бүгд Найрамдах Либерии Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
94	Ливи Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
95	Бүгд Найрамдах Тунис Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
96	Бүгд Найрамдах Бенин Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
97	Бүгд Найрамдах Замби Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
98	Бүгд Найрамдах Мадагаскар Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
99	Сейшелийн Арлуудын Бүгд Найрамдах Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
100	Бүгд Найрамдах Зимбабве Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
101	Лесотогийн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	4-р сарын 1-нээс 3-р сарын 31
102	Коморосын Холбооны Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
103	Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс https://www.cabri-sbo.org/en/countries/south-sudan	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
104	Бүгд Найрамдах Малави Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
105	Бүгд Найрамдах Гамби Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
106	Бүгд Найрамдах Кени Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
107	Эритрей Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
108	Бүгд Найрамдах Бурунди Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
109	Бүгд Найрамдах Того Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
110	Бүгд Найрамдах Сьерра Леон Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
111	Бүгд Найрамдах Уганда Улс https://www.indexmundi.com/uganda/fiscal_year.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
112	Бүгд Найрамдах Руанда Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
113	Экваторын Гвинейн Бүгд Найрамдах Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
114	Бүгд Найрамдах Чад Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
115	Бүгд Найрамдах Маврики Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
116	Бүгд Найрамдах Габон Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31

117	Бүгд Найрамдах Нижер Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
118	Бүгд Найрамдах Камерун Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	7-р сарын 1-нээс 6-р сарын 30
119	Бүгд Найрамдах Жибути Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
ЕВРОП ТИВИЙН УЛС ОРНУУД		
120	Оросын Холбооны Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
121	Бүгд Найрамдах Албани Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
122	Бүгд Найрамдах Польш Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
123	Бүгд Найрамдах Болгар Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
124	Бүгд Найрамдах Беларусь Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
125	Унгар Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
126	Украин Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
127	Румын Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
128	Бүгд Найрамдах Серби Улс https://www.nationmaster.com/country-info/stats/Economy/Fiscal-year	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
129	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	Засгийн газар, аж ахуйн нэгж байгууллага 4-р сарын 1-нээс 3-р сарын 31 Иргэн 4-р сарын 6-наас 4-р сарын 5
130	Бүгд Найрамдах Австри Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
131	Бүгд Найрамдах Финланд Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
132	Швейцарын Холбооны Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
133	Шведийн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
134	Бүгд Найрамдах Франц Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
135	Бүгд Найрамдах Грек Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
136	Норвегийн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
137	Данийн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31

138	Бүгд Найрамдах Итали Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
139	Бельгийн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
140	Нидерландын Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
141	Бүгд Найрамдах Кипр Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
142	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
143	Бүгд Найрамдах Исланд Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
144	Бүгд Найрамдах Португал Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
145	Люксембургийн Их Гүнт Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
146	Испанийн Хаант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
147	Бүгд Найрамдах Мальта Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
148	Бүгд Найрамдах Сан Марино Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
149	Монакогийн Хант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
150	Андоррын Хант Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31
151	Бүгд Найрамдах Ирланд Улс https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html	1-р сарын 1-нээс 12-р сарын 31

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://blog-pfm.imf.org/pfmblog/2016/10/the-timing-of-the-governments-fiscal-year-.html>
- <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/228.html>
- <https://www.nationmaster.com/country-info/stats/Economy/Fiscal-year>
- https://www.indexmundi.com/uganda/fiscal_year.html
- <https://www.cabri-sbo.org/en/countries/somalia>
- http://www.fdi.gov.cn/1800000121_39_2663_0_7.html
- https://www.indexmundi.com/philippines/fiscal_year.html
- https://www.indexmundi.com/marshall_islands/fiscal_year.htm
- https://www.indexmundi.com/federated_states_of_micronesia/fiscal_year.html